






ПАРЛАМЕНТЫН НОМЫН САН

ШИНЭ НОМЫН МЭДЭЭ  
2022 #3

1		<p>Бат-Эрдэнийн Батбаяр (Баабар). <b>Монгол – Япон: түүхэн харилцаа</b> /Ред. Д.Сандаг, Ито Ёрико .-УБ.: Нэпко, 2022.- 243х.- ISBN9789919511210</p> <p>Уг номонд Монгол, Япон орны түүхийг Халх голын дайн зэрэг түүхэн, бодит үйл явдал, баримтуудад түшиглэн хоёр орны харилцаа, стратеги бодлогын талаар товч, тодорхой өгүүлсэн.</p>
2		<p>Отгонбаяр Ё. <b>Монголын гээгдсэн түүх</b> /Ред. Д.Мягмарсүрэн УБ.: Нэпко, 2022.- 210х .- ISBN9789919511340.</p> <p>Монголын гээгдсэн, гүтгэгдсэн, мартагдсан, мушгигдсан түүхийн эдрээт замналыг баримтад түшиглэн өгүүлсэн байна.</p>
3		<p>Баабар. Г ба бус. <b>Хэн нь хэн бэ</b> /Ред.Б.Болдбаатар, Б.Цэнддоо.-УБ.: Нэпко, 2022.- 433х .-ISBN9789919511135</p> <p>Төв Азийн нүүдэлчдийн түүх, түүний нэгэн бүрэлдэхүүн хэсэг Монгол үндэстний түүхэнд холбогдох 1,500 орчим хувь хүний товч намтрын цуглуулгыг номонд багтаажээ.</p>
4		<p>Ли Жөү. <b>Экологийн эдийн засаг хийгээд зохицолт нийгэм</b> /Орч. А.Ану /Ред. Чү Фүтиан, Сүнь Руомэй.-УБ.: Нэпко, 2021.-304х .- ISBN9789919511197</p> <p>Экологийн хэрэглээний танин мэдэхүй түвшин, экологийн шошго, тэмдэгт итгэх итгэлийн түвшин бодлогын сурталчилгааны төлөв, барааны чанарын найдвартай түвшин зэргийг энэхүү номонд тодорхой тусгасан.</p>
5		<p>Ли Ининг, Шү Шяонинг. <b>Хот -Хөдөөгийн нэгдэл ба ядуурлыг бууруулах нь</b> /Орч. А.Ану /Ред. ЗуоЧангШэнг.-УБ.: Нэпко, 2022.- 173х .-ISBN 991951120.</p> <p>Хятадын засгийн газар хөдөө орон нутгийн бүтээн байгуулалтын шинэ бодлогыг гаргаж хэрэгжүүлэн тус улсын эдийн засгийн стратегийн шинжтэй зохицуулалтыг хэрхэн хийж амжилтанд хүрсэн талаар уг номонд өгүүлжээ.</p>
6		<p>Цэрэннадмид .Ч <b>Монгол улсын “гуравдагч хөрш” -ийн бодлого: туршлага ба асуудал - Монгол, Туркийн харилцаа</b> .-УБ.: Удам соёл, 2020.-226х.-ISBN9789919240813.</p> <p>Номын зохиогч нь Турк судлалын чиглэлээр мэргэшиж буй залуу эрдэмтэн бөгөөд тэрээр номондоо Турк улсын гадаад бодлогын онцлог, хувиралт, өөрчлөлт, Монгол улсын гуравдагч хөршийн бодлогод Турк улсын эзлэх байр суурь, гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдлыг шинэчилсэн олон чухал санаа дүгнэлтийг дэвшүүлсэн байна.</p>

7		<p>Лин Шанли. <b>Орчин үеийн Хятадын улс төр</b> /Орч. А.Ану, /Ред. Н.Нандинчимэг.-УБ.: Нэпко, 2022.- 511х.-ISBN9789919511180.</p> <p>Хятадын орчин үеийн улс төр чухамдаа Өрнөдийнх үү эсвэл Хятадынх уу, өрнийн логикийн дагуу явах ёстой юу, эсвэл Хятадын логигоор явах ёстой юу? зэрэг эргэлзээт, ээдрээтэй асуултуудад бүх талын, гүнзгий хариултыг эл номноос Та авна.</p>
8		<p>Тимоти Снайдэр. <b>Дарангуйлал : ХХ зууны хорин сургамж</b> /Орч.Д.Баярхүү /Ред.С.Баяраа .-УБ.: Нэпко, 2022.- 105х .- ISBN9789919500726.</p> <p>Хүн төрөлхтөн дарангуйллын хар сүүдэрт нэрвэгдэж, алдаж оносон үеийн томоохон 20 сургамжийг энэ номонд нэрлэж, өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан бичжээ.</p>
9		<p>Оюунчимэг Б. <b>Ёс зүй: ёс суртахууны тухай ном</b> .-УБ.: Бемби сан, 2019.-388х .-ISBN9789996291326</p> <p>Зохиогч номондоо бидний өдөр тутмын амьдралд тохиолддог ёс зүйн хэм хэмжээнүүдээс мэргэжлийн ёс зүй, бизнесийн ёс зүй, хэрэглээний ёс зүйн талаар сонгон авч дэлгэрэнгүй тайлбарлажээ.</p>
10		<p>Энни Дьюк. <b>Шийдвэр хэрхэн гаргах вэ: Оновчтой сонголт хийхэд тань туслах энгийн аргууд</b> /Орч. Гандарь.З, Ред. Г.Даваажаргал.- УБ. : Мөнхийн хүсэг, 2022.- 319х. ISBN9789919968465</p> <p>Хувь хүний хөгжлийн эл номонд бидний бодох үйл явц болон бодол санааны гүндээ хэрхэн нэвтрэх, бодлоо хэрхэн удирдан шийдвэр гаргах энгийн аргуудыг өгүүлсэн.</p>
11		<p>Майкл Делл.<b>Зөв ажилла зүтгээд хүр</b> /Орч.Т.Ариунсанаа /Ред.Уянга.В.-УБ.: Нэпко, 2019.- 286х.- ISBN9789919511132</p> <p>Делл технологийн компанийг үндэслэгч, ерөнхий захирал Майкл Делл удирдагч болох замд нь тохиолдсон ялалт, саад бэрхшээлийг хэрхэн туулсан талаарх ажил, амьдралын түүхээ өгүүлжээ.</p>
12		<p>Жордан Б. Питерсон. <b>Дэг журмын цаана : Амьдралын нэмэлт 12 дүрэм</b> /Орч.О.Онон /Ред .Э. Цэнгэлсайхан.-УБ.: Адмон принт, 2020.-356х .-ISBN97899997319593</p> <p>Дэлхийн бестселлер Хаосын эсрэг ерөндөг номын зохиогч Жордан Б.Питерсон нь амьдралын дасгалжуулагч, зарчимч, идеалист хүн бөгөөд тэрээр номондоо амжилттай хүний эрхэмлэх хүмүүжлийн 12 дүрмийг боловсруулжээ.</p>

13		<p><b>Кэл Ньюпорт. Гүн үйл: Сатаарсан нийгэмд төвлөрөх замаар амжилтанд хүрэх дүрмүүд</b> /Орч.П.Саруул.- Ред.Я.Ганхуяг Д.Гэрэлмаа .-УБ.: Грандбук Пабблишинг, 2021.- 274х .-ISBN9789919959432</p> <p>Уг ном ширүүн өрсөлдөөнт зах зээлийн өнөөгийн үед амжилтанд хүрч, ялгарахыг хүссэн хэн бүхэнд зориулсан гарын авлага болно.</p>
14		<p><b>Жаргал .Г, Сэлэнгэ.Н. Багаар ажиллах урлаг</b> /Ред.Ч.Санжмятав.- УБ.: Арилдал, 2019.- 168х. ISBN9789997898777</p> <p>Багаар ажиллах чадвартай гэж хүн бүхэн өөрийгөө хэлдэг, үнэлдэг боловч төдийлөн чаддаггүй, тэгвэл энэ чадвар, урлагийг эзэмшихэд туслах гарын авлага нь энэ ном юм.</p>
15		<p><b>Мари Кондо, Скотт Сонэнштейн . Баяр баясал авчрах ажлын эмх цэгц = Joy at Work</b> /Орч.Л.Саруултөгс /Ред.Б.Батцэцэг Д.Очирмаа.-УБ.: Адмон принт, 2021.-269х.-ISBN9789997319265</p> <p>Энэхүү ном нь олон улсад хэдийн алдаршсан” КонМари” эмхэлж цэгцлэх арга болон бодит судалгааны үр дүнд тулгуурлан таны хийж буй ажлаасаа аз жаргалыг мэдэрч, илүү бүтээлч, идэвхтэй ажиллах орчноо бүрдүүлэхэд хийгээд оюун санааны эмх цэгцээ олоход тань дэм, түлхэц болно.</p>
16		<p><b>Волтэр Айзексон. Геномын код тайлагч</b> /Орч.Т.Ариунсанаа, /Ред. Б.Нэргүй В.Уянга .- УБ.: Нэпко, 2022 .-542х.- ISBN9789919511395</p> <p>Хэдэн зууны явцад хүний бие организмуудад "байгалийн" жамаар тохиолдсон олон олон хувьслын эцэст бид эдүгээ амьдралын кодыг хакердан өөрсдийн генетикийн ирээдүйг хэрхэн инженерчлэх чадвартай болсон талаар номонд өгүүлнэ.</p>
17		<p><b>Жэймс Нэстор. Амьсгал</b> /Орч. С.Түмэндэмбэрэл Л.Өлзийсайхан.- УБ.: Нэпко, 2022.-274х . ISBN 9789919511401</p> <p>Номонд хүн төрөлхтний хувьсал, анагаах ухааны түүх, тамирчдын тэсвэр тэвчээр зэрэг маш олон зүйлийн талаар эрэл хайгуул хийсэн талаар өгүүлэх бөгөөд та өөрийгөө шинжилж таних боломжийг олгон, буруу амьсгалснаас үүдэх нойргүйдэл, харшил, багтраа, шүд амны гаж хөгжил, цаашлаад стресс бухимдал, сэтгэлзүйн асуудлын уг үндэс чухам юу вэ гэдгийг мэдэх болно.</p>

18		<p>Буянзаяа.Ц <b>Монгол уран зохиолын түүхэн товч. 2 дэвтэр</b> /Ред.Г.Даваажаргал.- УБ.: 2022.- Фриймон.</p> <p>Тэргүүн дэвт.: Чулуун номноос хөлгөн сударт. 350х. ISBN9789992988886.</p> <p>Дэд дэвт.: Хаан ширээнээс харцын олбогт. 466х. ISBN9789919264277</p> <p>Эрт үеийн монгол уран зохиолын хөгжилд уран зохиолын бүхий л төрөл зүйлсийн хэлбэршлийг бий болгосон байдгийг тэргүүн дэвтэрт тоймлон өгүүлсэн бол дэд дэвтэртээ 1920-оод оны эхэн үеэс 2000 оны эхэн хүртэлх Монголын уран зохиолын түүхэнд холбогдох бүтээл туурвилуудын уран сайхны онцлог шинжүүдийг хураангуйлан өгүүлжээ.</p>
----	---	---

2022.06.20